



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 03-Р УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 оны 10-р сарын 08-ны өдөр

Орхон аймаг

Нэг. Хяналтын үндэслэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 02/529 тоот албан даалгаврын дагуу Шилэн дансны тухай хууль тогтоомж, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд үндэслэнэ.

Хоёр. Хяналтын зорилго

Шилэн дансны цахим хуудасны Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл 2025 оны 03-р улирлын хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд хяналт хийж, зөрчлийг арилгуулахад зорилго оршино.

Гурав. Хяналтын хамрах хүрээ

Шалгалтыг 2025 оны 03-р улирлын Шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хооронд хугацаанд Нийгмийн даатгалын газрын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга Г.Галбадрах шалгалтыг хийж гүйцэтгэн ажилласан.

Дөрөв. Шилэн дансны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал

- Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны шилэн дансны нийт 171 мэдээлэл оруулахаас хагас жилийн байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 112, хугацаа хоцорсон мэдээлэл 14, мэдээлээгүй 45 байна
- Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас хагас жилийн байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 107, хугацаа хоцорсон мэдээлэл 10, мэдээлээгүй 42 байна.

Тав. Хяналтын үр дүн

Үйл ажиллагааны мэдээлэл оруулахдаа:

- Сар бүр, жил бүр, тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй, хавсралтад оруулах мэдээллээ дутуу, буруу оруулж тайлагнасан боловч тухай бүр оруулах мэдээллээ сүүлийн саруудад хоцролгүй оруулж байгаа сайн талтай байна.
- Мэдээлэл байршуулсан хувь:

Нийт мэдээлэл байршуулсан хувь-100%

Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь-88.8%

Сангийн мэдээллийн оруулахдаа:



- Тухай бүр оруулах мэдээллийг хугацаа хоцорч оруулах, оруулах мэдээллийг давхар бүртгэж илүү оруулах зэрэг алдаанууд байна.
- Мэдээлэл байршуулсан хувь:
Нийт мэдээлэл байршуулсан хувь-100%
Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь-91.4%

Зургаа. Шилэн дансны мэдээлэл байршуулалттай холбоотой илэрсэн зөрчил

Үйл ажиллагааны шилэн дансны дансны мэдээлэлд:

1.Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайланг оруулсан, өмнөх улирлаас хоцорсон мэдээллийн тоог бууруулсан боловч 2025 оны 09 дүгээр сард “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” мэдээлэлд цалин болон ЭММЗ-ийн урамшууллын зардлаас 90.5 сая төгрөгийг буцаан татсан гүйлгээг хугацаа хоцорч байршуулсан.

2.Төсвийн хэтрэлт хэмнэлтийн тайлбарыг бүрэн оруулаагүй тайлагнасан.

Сангийн шилэн дансны дансны мэдээлэлд:

1. Сар бүр, жил бүр, Тухай бүр оруулах мэдээний хавсралт цэсэд мэдээлэл байршуулаагүй тайланг оруулсан.

2. Тухай бүр оруулах мэдээллийн байршуулалтад гарсан алдаа:

Шалгалтын явцад илүү мэдээлсэн 5 гүйлгээний 8,976.6 сая төгрөгийн мэдээллийг засаж, дутуу мэдээлсэн 12 гүйлгээний 9,168.7.2 сая төгрөгийн гүйлгээг нөхөн байршуулж нийт 17 гүйлгээний 18,145.3 сая төгрөгийн гүйлгээний зөрчлийг арилгасан.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ	Хяналт шинжилгээний явцад зөрчлийг арилгаж нөхөн байршуулсан мэдээлэл /Сая.төгрөг/		Илүү мэдээлсэн дүн /Сая.төгрөг/		Дутуу мэдээлсэн дүн /Сая.төгрөг/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын мөнгөн гүйлгээ	6	8,961.9	0	0	6	8,961.9
Зарлагын мөнгөн гүйлгээ	6	206.8	5	8,976.6	6	206.8

Долоо. Зөвлөмж

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулгыг харгалзах оруулах мэдээлэл байхгүй үед шалтгааныг нь тайлбарлан бичиж, дарааллын дагуу бүх цэсийг бүрэн дарж баталгаажуулах, мэдээ оруулах хуулийн хугацааг өдөр бүр орж шалгаж хэвших, хэмнэлт хэтрэлтийн тайлбарыг бүрэн гүйцэт бичиж оруулах, тухай бүр оруулах мэдээллийг шийдвэр гарсны дараа 7 хоногийн дотор байршуулах, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэрийг нягтлан бодогчид 5 хоногийн дотор өгч хэвших, хавсралт цэстэй байгаа мэдээлэлд хавсралтыг бүрэн оруулж цаашид алдаа дутагдлаа давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

Найм. Дүгнэлт



Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн нийт 330 мэдээллээс сар, улирал бүр, эхний хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс хуулийн хугацаанд 219 мэдээллийг байршуулсан боловч 24 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнасан. Тухай бүр оруулж байршуулах мэдээллийн шийдвэр гарсан болон орлого зарлагын гүйлгээ хийсний дараа 7 хоногийн дотор байршуулаагүй зэрэг алдаа дутагдлаа дээд газрын болон дотоодын шалгалтын явцад арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

Ес. Цаашид авах арга хэмжээний санал

1.Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах дээд шатны байгууллагаас өгсөн зөвлөмжийг заалт бүрээр мөрдөж ажиллах

3.Цаашид мэдээлэл хоцроохгүй байхад чиглэсэн ажлын хуваарилалтаа дахин сайжруулах арга хэмжээ, зохион байгуулалтыг хийж, алдаа гаргахгүй байх